

ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 28

Буянт-Ухаа

ИНЕГ-ын харьяа “Чингис хаан” ОУНБ-ын хамт олон нь 2017 онд байгууллагын санхүүгийн нөөцийн ашиглалтыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, шинэ нисэх буудал руу нүүх бэлтгэлийг хангах, хүний нөөцийг чадваржуулах зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн тулд Иргэний нисэхийн тухай хууль, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан стандарт, Иргэний нисэхийн багц дүрмүүд, Иргэний нисэхийн Аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр, Онцгой байдлын үед ажиллах журам, ИНЕГ-ын болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон ажиллалаа.

“Чингис хаан” ОУНБ нь ИНЕГ-аас батлагдсан 6 хэлтэс, 1 тасаг, 9 албатай, 752 орон тооны ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

2017 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийт 61 ажил хийхээр төлөвлөснөөс 37 ажил 100%, 11 ажил 90%, 7 ажил 70%, 2 ажил 50% хэрэгжиж, 4 ажил хөрөнгийн асуудлаас шалтгаалан хойшлогдсон байна. Нийт дүнгээр төлөвлөгөөний биелэлт 92,6%-тай хэрэгжсэн байна.

Тайлангийн хугацаанд удирдах дээд байгууллагаас гаргасан албан даалгавар, удирдлагын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Тухайлбал:

- МУ-ын Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгавар,
- МУ-ын Засгийн газрын “Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгавар,
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02, 18 тоот албан даалгавар,
- ИНЕГ-ын даргын 2017 оны 01, 02, 03, 04 тоот албан даалгавар,
- ИНЕГ-ын Тэргүүн дэд даргын 02/02, 02/03 тоот албан даалгавруудыг ажилтнуудад танилцуулах, цахим хуудсанд байршуулах, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, хэрэгжилтийн тайлан, мэдээг удирдах дээд байгууллагад хүргүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ИНЕГ-ын даргын 138 тушаал ирснээс 124 тушаал бүрэн хэрэгжиж, 14 тушаал хэрэгжилтийн шатандаа байна.

“Чингис хаан” ОУНБ-ын захирлын 816 тушаал гарч хэрэгжсэнээс үйл ажиллагааны чиглэлийн А/126, хүний нөөцийн чиглэлийн Б/690 тушаал гарсан байна.

Удирдах дээд байгууллага болон гадны байгууллагаас 2797 албан бичиг хүлээн авч, 2011 албан бичгийг ИНЕГ болон бусад байгууллагад явуулсан.

Мөн иргэд болон ажилтнаас нийт 584 өргөдлийг хүлээн авч, 574 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Одоогоор 10 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

2017 онд “Чингис хаан” ОУНБ-ын захирлын зөвлөлийн хурлыг 6 удаа зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан

Тус нисэх буудлын үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнийг 49 удаа зохион байгуулж, нийт 472 үүрэг даалгавар өгөгдсөн нь 92%-ийн биелэлттэй байна. Мөн ЗТХЯ-ны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 5, ИНЕГ-ын Тэргүүн дэд даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 170, НББЗХ-ийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 280 үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэн ажилласан.

*Байгууллагын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр*

2017 оны үйл ажиллагааны зорилтын хүрээнд Аюулгүй ажиллагааны болон Чанарын удирдлагын тогтолцоог хангах чиглэлээр боловсруулсан баримт бичгүүдээс гадна Монгол улсын хууль, тогтоомж, Иргэний нисэхийн дүрмүүд болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан стандарт шаардлагуудад нийцүүлэн нисэх буудлын үйлдвэрлэлийн

үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн баримт бичгүүдийг шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах, шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлын хүрээнд шинэчлэн баталсан 36 баримт бичиг, нэмэлт өөрчлөлт оруулсан 6 баримт бичгийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээр нисэх буудлын мэдээллийн сан “Мастер лист”-д нийт 264 баримт бичиг бүртгэлтэй болсон байна.

ИНЕГ-ын даргын 2016 оны А/825 дугаар тушаалаар “Чингис хаан” ОУНБ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан хэлтэс, албадын Ажлын чиг үүргийг шинэчлэсний дээр 142 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, 35 ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулан мөрдсөн.

Түүнчлэн ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамтай нийцүүлэн “Чингис хаан” ОУНБ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 4.1.11.2 дахь заалтад өөрчлөлт оруулж, Захирлын 2017 оны А/78 дугаар тушаалаар баталсан.

ИНЕГ-ын даргын 2017 оны “Тушаалын хавсралтыг хүчингүй болгох тухай” А/441 дүгээр тушаалын дагуу “Хөдөлмөрийн гэрээний нэмэлт өөрчлөлт оруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай” “Чингис хаан” ОУНБ-ын захирлын 2016 оны А/26 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан туршилтын болон түр гэрээний загварыг Захирлын 2017 оны А/76 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

“Чингис хаан” ОУНБ-ын “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх журам”-ыг Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай үйл ажиллагааг зохицуулах журам” болгон шинэчлэн боловсруулж, баталгаажуулан мөрдөж байна.

Зорчигч үйлчлүүлэгчдэд шуурхай соёлтой үйлчилгээг үзүүлэх, үйлчлэгч, үйлчлүүлэгчдийн харилцааг тодорхойлох зорилго бүхий “Үйлчилгээний стандарт”-ыг “Үйлчилгээний ажилтны заавар” нэртэйгээр шинэчлэн боловсруулсан.

“Чингис хаан ОУНБ-ын Онцгой байдлын үед ажиллах журам”-ыг “Онцгой байдлын төлөвлөгөө” нэртэйгээр шинэчлэн боловсруулж, НААХЗА-аар хянуулж, батлуулсан.

“Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага” MNS ISO 9001:2016-ын дагуу “Чингис хаан” ОУНБ-ын “Чанарын гарын авлага”, “Дотоод аудит хийх журам”-ыг тус тус шинэчлэн боловсруулсан.

“Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог схемчлэн батлуулах, аюулгүй ажиллагааны хороо, аюулгүй ажиллагааны хэсгийг томилох, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны зааварт нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

“Олон улс, орон нутгийн ирэгчдийн танхимын ашиглалтыг сайжруулах заавар”-т олон улсын зорчигчийн бүртгэлд орон нутгийн бүртгэлийн цэгийг ашиглах зохицуулалтыг нэмж тусган баталгаажуулсан.

“Чингис хаан” ОУНБ болон Нислэг хөдөлгөөн үйлчилгээний албатай харилцан ажиллагааны журам, Техник хангалт, навигацийн үйлчилгээний албатай хамтын ажиллагааны журам зэрэгт нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

“Чингис хаан” ОУНБ-ын Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөрийг үндэслэн энгийн үйлчлүүлэгчдэд зориулан “Чиглүүлэх үйлчилгээ”-г нэвтрүүлэхээр төлөвлөн “Угтах үйлчилгээ”-ний зааврыг боловсруулж байна.

Мөн 2017-2018 оны өвлийн тогтмол нислэгийн цагийн хуваарийн төсөлтэй танилцаж, нислэгийн давхцалын талаар болон зуны нислэгийн гүйцэтгэл, саатлын мэдээг нэгтгэн боловсруулж ИНЕГ-ын “Нислэгийн цагийн хуваарийн зөвлөл”-ийн хуралд танилцуулсан.

“Чингис хаан” ОУНБ-ын дамжин өнгөрөх танхимын ашиглалтыг сайжруулахтай холбогдуулж агаарын тээвэрлэгч байгууллагуудын дамжин өнгөрөх зорчигчдын тарифт судалгаа хийж, тогтмол нислэг гүйцэтгэдэг 4 агаарын тээвэрлэгч байгууллагын үнэ тариф, нисэх буудлын хураамжуудад харьцуулалт хийсэн. Энэхүү судалгаан дээр үндэслэн “Дамжин өнгөрөх урсгалыг сайжруулах бизнес төлөвлөгөө” боловсруулж байна.

2017 онд Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-д Монгол улсаас анх удаа Чикагогийн конвенцийн Хавсралт 9-ын стандарт, зөвлөмжүүдийн нийцэл, ялгаа зөрүүг мэдээлэх ажил хийгдэхэд Хавсралт 9-ийн стандарт, зөвлөмжүүд МУ-ын хууль, дүрэм, хөтөлбөр, журам, зааварт хэрхэн тусгагдсан, зөрүүтэй байдлыг илтгэх нийцлийн 120 хуудсыг бөглөх ажлыг гүйцэтгэн, ИНЕГ-ын НББЗХ, НААХЗА-ны холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцийн Хавсралт 9 (Үйл ажиллагааг хялбарчлах)-д орсон нэмэлт өөрчлөлтийг Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрт тусган Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр гарган НББЗХ-т хүргүүлсэн.

Түүнчлэн аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагааны заавар, Аюулгүй байдлын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, НААХЗА-аар хянуулан баталгаажуулсан.

Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын хамгаалалтын түр журмыг боловсруулан ИНЕГ-ын даргаар батлуулан мөрдөж байна.

Аюулгүй байдлын хорооны бүрэлдэхүүнийг Захирлын 2017 оны А/141 тушаалаар шинэчлэн байгуулж, 2017 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу аюулгүй байдлын хорооны хурлыг 3 удаа хуралдуулж, 12 асуудлыг шийдвэрлэсэн. Аюулгүй байдлын хорооны 2017 оны төлөвлөгөө 98,5%-ийн хэрэгжилттэй байна.

Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн дагуу харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгуулан ажиллаж байна.

Мөн “Чингис хаан” ОУНБ-ын Аэродромын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгахтай холбоотойгоор бэлтгэл ажлыг хангаж, 2017 оны 11 дүгээр сард Аэродромын үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээг авсан.

2017 оны 05 дугаар сард Стандартчлал хэмжилзүйн газраас тус нисэх буудлын чанарын удирдлагын тогтолцоонд аудитын шалгалт хийж, Чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай эзэмших эрхээ авсан.

#### *Санхүү, эдийн засгийн үзүүлэлт*

“Чингис хаан” ОУНБ нь 2017 онд 80,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн дансадаа шилжүүлэн авснаар 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 80,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 27,8 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10,9 тэрбум төгрөгийн авлагатай байна.

Мөн 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 29,9 тэрбум төгрөгийн орлоготой, 24,6 тэрбум төгрөгийн зардалтай, 5,3 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын 27,6 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого, 2,4 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 19,9 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардал, 2,1 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна.

2017 онд дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудтай байгуулсан авлага барагдуулах гурван талт гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, “МИАТ” ХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн зуны сард өдөр бүр 22 сая, өвлийн сард 10,5 сая төгрөг төлөхөөр, “Хүннү эйр” ХХК, “Аэромонголиа” ХХК-тай 09 дүгээр сараас өвлийн саруудад өдөр бүр 2 сая, зуны саруудад өдөр бүр 3 сая төгрөг төлөхөөр гэрээ хийсэн. Үүнээс “МИАТ” ХК 13.3 тэрбум, “Хүннү Эйр” ХХК 823 сая, “Аэромонголиа” ХХК 428 сая төгрөгийн авлагыг барагдуулж, “МИАТ” ХК 5,4 тэрбум, “Хүннү Эйр” ХХК 3,3 тэрбум, “Аэромонголиа” ХХК 1,4 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

#### *Үндсэн үйл ажиллагаа*

*Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах чиглэлээр:* “Чингис хаан” ОУНБ нь 2017 онд олон улсын 16 чиглэлд дотоодын агаарын тээвэрлэгч 3, гадаадын 5 авиа компани, орон нутгийн 10 чиглэлд дотоодын агаарын тээврийн 3 байгууллагын тогтмол болон захиалгат нислэгүүдэд үйлчилгээ үзүүлж, зорчигчдын үйлчилгээ, тэдгээрийн тав тухтай зорчих нөхцөл, аюулгүй байдлыг хангах, агаарын хөлгөөр тээвэрлэгдэх ачаа, шуудангийн аюулгүй байдлыг ханган тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах, хадгалах үйлчилгээг үзүүлэх нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 24 цагийн турш явуулж байна.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нийт 1 241 506 зорчигч үйлчлүүлснээс олон улсын чиглэлд 926 089, орон нутгийн чиглэлд 315 417 зорчигч байна. Зорчигчийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21,9%-иар өссөн байна. 2017 онд транзитаар 859 зорчигч зорчсон. Нисэх буудлаар 13 326 нислэг үйлдэгдэж, үүнээс захиалгат 3122, нэмэгдэл 80, тусгай 96, онцгой үүргийн 38 нислэг тус тус үйлдэгджээ. Нислэгийн тоог өмнөх оны мөн

үетэй харьцуулахад 16,9%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь олон улсын чиглэлд 3, орон нутгийн чиглэлд 1, нийт 4 нислэг шинээр нэмэгдсэнтэй холбоотой юм.

Ачаа шуудан үйлчилгээний цогцолбороор олон улсад 972 тн ачаа, 52 тн шуудан илгээгдэж, 3954 тн ачаа, 285 тн шуудан тус тус хүлээн авсан. Орон нутгийн чиглэлд 39 тн ачаа, 48,6 тн шуудан илгээгдэж, 7,7 тн ачаа, 10,4 тн шуудан хүлээн авсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ачаа тээвэрлэлт 12,5%-иар өсч, шуудан тээвэрлэлт 16,8%-иар буурсан байна.

Ачаа, шуудан үйлчилгээний цогцолборт Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 2,4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна.

2017 онд “Хүннү эйр” ХХК-ийн нислэгийн шилжин суух зорчигч тээвэрлэх үед агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээг урьдчилан ирүүлэх, нисэх буудлаас тээш хадгалах тасалгаа гаргуулах ажлыг төлөвлөн зохицуулж, олон улсын тээшний хэсэгт тусгай тасалгаа гаргаж “Хүннү эйр” ХХК-д хүлээлгэн өгсөн.

2017 онд Төрийн Хүндэт зочны танхимаар 9465, орон нутгийн Хүндэт зочны танхимаар 1495, Бизнес танхимаар 21523, Транзит танхимаар 859 зорчигч үйлчлүүлсэн ба онцгой болон тусгай үүргийн 19 нислэгийн ёслолын үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж ажилласан.

2017 оны 08 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хурлын зочид, төлөөлөгчдийг нисэх буудлаар угтан авах, үдэн гаргах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж ажилласан.

*Аюулгүй байдлыг хангах чиглэлээр:* Аюулгүй байдал, хамгаалалтын алба нь нисэх буудлын барилга, түүний орчин болон нислэгт гарч буй агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус халдлагаас хамгаалах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигчид болон хориотой, хамгаалагдсан бүсэд нэвтэрч байгаа хүмүүсийн бие, гар тээш, ачаа, тээврийн хэрэгсэлд иргэний нисэхийн холбогдох дүрэм, журмын дагуу үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Тус алба Иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалж аюулгүй байдлыг хангах ИНД140-ийн дагуу, Аврах гал унтраах алба нь болзошгүй гал ослын үед агаарын хөлгийг авран хамгаалах, гал унтраах ажиллагаа явуулах ИНД-139 дүрмийн дагуу тус тус гэрчилгээжсэн.

Тайлант хугацаанд “Чингис хаан” ОУНБ-ын Аюулгүй байдлын хөтөлбөрийг 100% хэрэгжүүлж ажилласан. Хөтөлбөрийн биелэлтийг ИНЕГ-ын НББЗХ-т хүргүүлсэн.

Иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, технологийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, аюулгүй байдлын ажилтнуудын ур чадвар, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор Аюулгүй байдал, хамгаалалтын албанд 2017 оны 04 дүгээр сард төлөвлөгөөт дотоод сорилтыг зохион байгуулж, сорилтыг нисэх буудлын олон улсын үзлэгийн цэг, В8, А19, А3 постуудад үүрэг гүйцэтгэж байгаа ажилтнууд дээр явуулсан.

Аюулгүй байдал, хамгаалалтын алба нь онцгой, тусгай үүргийн 37 удаагийн хамгаалалтад, Аврах гал унтраах алба нь онцгой, тусгай үүргийн хамгаалалтад 49, зорчигчтой сумалгаанд 39, объектын дуудлагаар 3, техникийн дутагдалтай нислэгийн 1, галын аюулгүй байдлын хамгаалалтад 1, кодоор 6, хөдөлгүүр шалгах хамгаалалтад 4, нийт 103 удаа дуудлаганд гарч ажилласан.

Аюулгүй байдлын үзлэгээр олон улсын чиглэлд 469 619 зорчигч, 1 407583 гар тээш, 365005 тээш, орон нутгийн чиглэлд 154 956 зорчигч, 824 732 гар тээш, 131 131 тээш, 71345 ачаа, шуудан, 8221 хайрцаг хоол хүнс шалгагдсан байна.

Хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтэрсэн хүн, тэдгээрийн гар тээш, тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтаар давхардсан тоогоор 1705148 хүн, 551370 гар тээш, 200359 тээврийн хэрэгсэл, түр үнэмлэхээр 31024 хүн, 1445 тээврийн хэрэгслийг шалгаж нэвтрүүлсэн. Нэг удаагийн үнэмлэхийг 4065 хүнд олгож, нэвтрүүлсэн байна.

Аюулгүй байдлын үзлэг, шалгалтаар 38492 хориглосон эд зүйлс, 802 зөвшөөрөлгүй сумыг тус тус илрүүлэн хураан авч, Иргэний агаарын тээврийн Цагдаагийн хэлтэст хүлээлгэн өгсөн.

Нисэх буудлын хориотой болон нийтийн эзэмшлийн бүсэд эзэнгүй орхисон 118 тээш, эд зүйлсэд холбогдох журмын дагуу үзлэг шалгалт хийж аюулгүй болохыг нь баталгаажуулан ИАТЦХ-т хүргүүлэн.

Нэвтрэх үнэмлэхний зөрчилтэй 54 хүн, 25 тээврийн хэрэгслийн үнэмлэхийг хураан авч, нэвтрэх цэгээр хутгатай орохыг завдсан 3, баримт бичгийн зөрчилтэй 8, согтууруулах ундаа хэрэглэсэн 16, бусад зөрчил гаргасан 76 хүний асуудлыг холбогдох журмын дагуу авч хөндлөнгийн хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж ажилласан байна.

2017 онд Аюулгүй байдал, хамгаалалтын албаны үйл ажиллагаанд 7 удаа дотоод хяналтын үзлэг шалгалт хийж, 66 зөрчлийг илрүүлэн түүний дагуу “Зөрчлийг засч залруулах арга хэмжээний төлөвлөгөө” гарган залруулах арга хэмжээг авсан.

Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүс, аюулгүй байдлын үзлэгийн цэгийн үйл ажиллагаанд шалгалт хийж эрсдэлтэй 10 цэгийг тодорхойлж, 9 цэгийн эрсдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

“Чингис хаан” ОУНБ-ын хориотой болон хамгаалагдсан бүсийн хүн, тээврийн хэрэгслийн нэвтрэх цэгүүдэд нэвтрэх үнэмлэхний хяналтын /Access Control System/ төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна.

Нисэх буудлын хамгаалагдсан болон хориотой бүсэд нэвтрэх хүний байнгын үнэмлэхийг 97 байгууллагын 5730 ажилтанд, түр үнэмлэхийг 47 байгууллагын 815 ажилтанд, тээврийн хэрэгслийн байнгын 277 үнэмлэх, 55 түр үнэмлэхийг тус тус олгосон.

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын хамгаалагдсан бүсэд нэвтрэх хүний байнгын үнэмлэхийг 3633 ажилтанд, тээврийн хэрэгслийн 1101 түр үнэмлэхийг олгосон. Тээврийн хэрэгслийн 354 үнэмлэхийг сунгасан байна.

Нэвтрэх үнэмлэхний талаарх мэдээллийн сургалтыг 54 байгууллагын 3157 ажилтанд явуулж зааварчилгаа өгч ажилласны дээр хүчингүй болсон 172 үнэмлэхийг нэвтрэх үнэмлэхний бүртгэлийн системд бүртгэсэн.

ИНЕГ-ын даргын 2017 оны А/360 дугаар тушаалын дагуу 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс АБХА-ны 37 хамгаалалтын ажилтан Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлын барилга байгууламж, объектыг хамгаалалтад авч 24/48 цагаар 8 постод үүрэг гүйцэтгэж байна.

2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан Иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр аюулгүй байдлын бие бүрэлдэхүүнд өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжин ажиллах, түргэн цугларалтын бүдүүвчийн дагуу тодотгол хийж ажилласан.

Нисэх буудлын нийтийн эзэмшлийн бүсэд 2 цагийн давтамжтайгаар албаны нохойтой эргүүл ажиллуулж хориотой, хамгаалагдсан бүсийн хашаа хамгаалалтыг тээврийн хэрэгсэл ашиглан шалгах давтамжийн тоог нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн бүсэд тавих камерын хяналтыг чангатган нислэгийн ачаалал ихсэх болон хяналтгүй орхигдсон эд зүйлс, сэжиг бүхий үйлдэл гарсан тохиолдолд АБХА-ны шуурхай бүлэг зохих арга хэмжээг авч ажилласан.

*Аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр:* Аэродром алба нь төв болон орон нутгийн нисэх буудлуудын аэродромын элементүүдийн ашиглалтын бэлэн байдлыг ханган ажилласан байна.

“Чингис хаан” ОУНБ-ын перрон талбайн агаарын хөлгийн зогсоолуудад 703, хөөрч буух хучилттай зурвас, явгалах замуудад 536, хөөрч буух шороон зурвас, явгалах замуудад 131, хамгаалалтын хашаа, үерийн суваг, шуудуунд 127, бага оврын тоног төхөөрөмжүүдэд 157 удаа үзлэг шалгалт хийж зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлсэн.

Аэродромын хучилттай элементүүдийн цас цэвэрлэгээг 70 удаа, үйрмэг цэвэрлэгээг 87 удаа хийж гүйцэтгэсэн ба технологийн алдаа дутагдал, нислэгийн саатал гаргаагүй болно.

2017 оны 11 дүгээр сард их хэмжээний нойтон цас орсонтой холбогдуулан Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын 2 Жетбрум /цас цэвэрлэгч машин/, дотоодын цэргийн 326 дугаар ангийн 50 алба хаагчийг нэмэлтээр ажиллуулж, аэродромын бэлэн байдлыг хангаж ажилласан.

Мөн аэродромын хөөрч буух хучилттай зурвасын хагарлын заадсаас шахагдаж ил гарсан 5445 у/м мастикийг хусч цэвэрлэн 12120 у/м хагарлыг мастикаар, перрон талбайн 3775

у/м хагарлыг, үерийн суваг болон пост 8-ын автозамын 12840 у/м хагарлыг тус тус гагнаж засварласан.

Аэродромын хучилттай элементүүдийн 66,24 м<sup>2</sup> талбайн эвдрэл, гэмтлийг нөхөн засварлаж ашиглалтын бэлэн байдлыг хангасны дээр аэродромын элементүүдийн 10305 м<sup>2</sup> талбайн будган тэмдэглэгээг сэргээн будсан.

Агаарын хөлгийн 7, 8, 24 дүгээр зогсоолуудын нийт 601,12 м<sup>2</sup> талбайд засвар хийсэн ба хөөрч буух шороон зурвасын 95000 м<sup>2</sup> талбайг индүүдэж нягтруулан засварласан.

Мөн албаны гадна талбайн авто машины зогсоол, гараашийн хаалга болон “Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын алба”-ны авто замын будган тэмдэглэгээг сэргээн будсан.

Хамгаалагдсан бүсэд хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, хөөрч буух шороон зурвас, перроны нийт 119560 м<sup>2</sup> талбайн өвсийг хадаж, аэродромын хамгаалалтын хашааны буланд хуримтлагдан тогтсон хамхуул, хагд өвсийг ачиж зайлуулсан.

2017 онд аэродромын аюулгүй байдлыг хангах үзлэг шалгалтыг 2815 удаа, аэродромын бэлэн байдлын мэдээг 357 удаа, хөөрч буух зурвасын гадаргуугийн барьцалт хэмжих журмын дагуу 119 удаа хэмжилт хийж, зурвасын байдлыг илтгэх METAR мэдээг Нисэхийн цаг уурын төв болон Нислэг хөдөлгөөний үйлчилгээний албанд 51 удаа шуурхай дамжуулж, 13089 удаа зогсоол хуваарилж ажилласан.

Аэродромын хучилттай элементүүдийн гадаргуугийн байдал, эвдрэл гэмтлийн хар зураглал, засварын ажлын мэдээллийг Равег программд оруулж, хөөрч буух хучилттай зурвас болон явгалах зам А, В, D-ын ашиглалтын байдлын үнэлгээ, гэмтлийн хэмжээг тооцоолон гаргасан.

Зурвасын байдлыг илтгэх METAR мэдээг Нисэхийн цаг уурын төв болон Нислэг хөдөлгөөний үйлчилгээний албанд 14 удаа шуурхай дамжуулсан. Явгалах замын засварын ажлыг “Бадрах ойл” ХХК гэрээний дагуу гүйцэтгэсэн ба үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.

Перрон талбай агаарын хөлгийн 9 дүгээр зогсоолын нийт 905м<sup>2</sup> талбайд нүхэн засвар, шороон болон хучилттай дотоод автозамын засварын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн хяналт тавьж ажилласан.

2017 онд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс шувууны аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг үргээлгийг 4085 удаа хийж, үүнээс 2409 тохиолдолд шувуу, мал амьтныг илрүүлэн үргээх төхөөрөмж, ангийн бууг ашиглан үргээсэн. Агаарын хөлгийн ойртолтын ажиглалт эргүүл хийсний үр дүнд үхсэн амьтдын 7 тохиолдлыг илрүүлэн, тэдгээрийг булах, зайлуулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Хамгаалалтын хашааны 240, 1334 дугаар хавтангуудын доорх үерийн ус зайлуулах шуудуу болон курс 14 талын торон хашаан доогуур нүх гарсныг зэрлэг амьтад аэродромын талбай руу нэвтрэхээс урьдчилан сэргийлж тороор битүүлсэн.

Мөн хярс устгах зорилгоор аэродромын талбайд 3 ширхэг хавх тавьсан ба хавх байрлуулсан газрыг анхааруулах зорилгоор “Анхаар хавх!” гэсэн тэмдэгийг ашиглаж байна.

Аэродромын алба нь орон нутгийн нисэх буудлуудын аэродромын бэлэн байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Завхан аймгийн “Доной” нисэх буудлын шинээр баригдаж буй хөөрч буух хучилттай зурвасын барилга угсралтын ажлын дүгнэлт гаргах ажлын хэсэгт 2 инженер, “Алтай” нисэх буудлын аэродромыг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисст 1 ахлах инженерыг тус тус ажиллуулсан ба “Ховд”, “Дэглий цагаан”, “Өлгий” нисэх буудлуудад хөөрч буух хучилттай зурвасын засварын ажлын хэмжээ гаргах, аэродромын хучилттай элементүүдийн гадаргуун байдлын үнэлгээ гаргах, хажуугийн болон төгсгөлийн аюулгүйн зурвасын даац (СBR)-ын хэмжилт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Өмнөговь аймгийн “Овоот” нисэх буудлын захиалгын дагуу хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, перроны ашиглалтын байдлын үнэлгээг Равег программаар тооцоолон гаргаж, хүргүүлсэн. Говь-Алтай аймгийн “Алтай” нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, перроны даацыг тодорхойлж ИНЕГ-ын “Нисэх буудлуудын бодлого зохицуулалтын хэлтэс”-т хүргүүлсэн.

2017 онд “Чингис хаан” ОУНБ-ын Онцгой байдлын үед ажиллах журмын дагуу 3 сургуулилтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 2 дасгал сургуулилтыг зохион байгуулахад оролцсон байна. Үүнд:

- ✓ ИНЕГ, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Нислэгийн аюулгүй ажиллагаа, нислэгт тэнцэх чадварыг хадгалах Хойд Азийн орнуудын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөр “COSCAP-NA”-ийн хүрээнд Улаанбаатар хотноо 2017 оны 6 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд “Онцгой байдлын төлөвлөлт” сэдвээр онолын, 2017 оны 06 дугаар сарын 29-нд ширээний дасгал сургуулилтыг Хөшигийн хөндийн Олон улсын шинэ нисэх онгоцны буудалд зохион байгуулагдахад оролцсон.
- ✓ 2017 оны 02 дугаар сарын 22-нд “Барилга байгууламжид гарсан гал түймэр”-ийн үед ажиллах КОД4-оор онцгой байдлын хэсэгчилсэн дасгал сургуулилтыг зохион явуулсан.
- ✓ МУ-ын Засгийн газрын 339, 340-р тогтоолын дагуу 2017 оны 03 дугаар сарын 23-нд орон даяар явагдсан гамшгийн үед зарлан мэдээлэх, газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний дасгал сургуулилтыг зохион байгуулахад амжилттай оролцсон.
- ✓ ИНЕГ, ТЕГ-тай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 07-нд зохион байгуулсан “барилга байгууламжийг тэсрэх хэрэгслээр заналхийлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээ” КОД 7-оор бүрэн хэмжээний дасгал сургуулилтад Онцгой байдлын төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийн дагуу оролцсон.

Тайлант хугацаанд “Чингис хаан” ОУНБ-ын Онцгой байдлын төлөвлөгөөний дагуу 3 удаа КОД зарлан нислэг үйлдвэрлэлийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажилласан. Үүнд:

- ✓ 2017 оны 03 дугаар сарын 14-нд Катар-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж байсан агаарын хөлгийн 3 дугаар хөдөлгүүр татгалзсан мэдээллийн дагуу КОД-3-оор ажилласан.
- ✓ 2017 оны 06 дугаар сарын 02-нд Улаанбаатар-Сэлэнгэ аймгийн чиглэлд нислэг үйлдсэн агаарын хөлөг тус нисэх буудлаас хөөрсний дараа осолдсон тул КОД-1 зарлаж ажилласан.
- ✓ 2017 оны 08 дугаар сарын 18-нд “МИАТ” ХК-ийн агаарын хөлгийн зүүн үндсэн дугуйны гадна резин их хэмжээгээр салбарч унасан байсныг илрүүлж, КОД-3 зарлаж ажилласан.

*Инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмж, ашиглалтын талаар:* Тус нисэх буудлын дулаан сантехникийн алба нь 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд зуны урсгал засварын ажил болон барилга, байгууламжуудын ариутгах татуургын 3400 метр шугам сүлжээг тусгай тоноглолын машинаар угааж, бохирын 140 худгийг цэвэрлэн ИНЕГ, түүний харьяа байгууллагууд болон нисэх буудлын ус дулаан дамжуулах төв, зангилааны дулаан /халаалт/-ын тоноглолд үзлэг үйлчилгээ хийж, халаалтыг залган цэвэр усны зангилааны хэмжих хэрэгслийн баталгаат хугацаа дууссан 9 тоолуурыг шалгаж баталгаажуулсан.

Мөн 3 манометр, 4 термометрийг шинээр тавьж, нисэх буудлын гадна ногоон байгууламжийн усалгааны системд 2 тоолуурыг угсарч, хэвийн ажиллагааг ханган ажилласан.

Цахилгаан агааржуулалтын алба нь нисэх буудлын харьяа нэгжүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгааны болон КИПА-ийн тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

2017 онд гэрэлтүүлэг болон гэрэлтүүлэгчийн цахилгаан тоноглолуудад 700м туузан гэрэл, 1034 гэрэлтүүлэгч, 970 өдөөгчийг сольж сэлбэсэн.

Нислэг үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд олон улс, орон нутгийн ачаа зөөврийн налуу, хэвтээ транспортёр, агаарын хөлөгт залгах хүзүүвч, автомат хаалга, зорчигчийн урсдаг шатанд техникийн үзлэг, үйлчилгээг тогтмол хийж, гарсан гэмтэл саатлыг тухай бүр нь засварласан. Мөн олон улс, орон нутгийн хэсгийн бүртгэлийн цэгүүдийн цахилгаан жингүүдийг 14 хоног тутам шалган, тохиргоо, зүгшрүүлэлт хийж ашиглагч агаарын тээвэрлэгч байгууллагуудад хүлээлгэн өгч байна. Агаарын хөлөгт залгах 3-р хүзүүвний удирдлагын хэлхээнд гарсан гэмтлийг тодорхойлж, сэлбэгийг суурилуулан, тохиргоо хийж хэвийн ажиллагаанд оруулсан.

Транзит болон бизнес танхимын тамхины өрөөний агаар сорох системийн техникийн нөхцөлийг гаргаж, шугам хоолойг өргөтгөн, угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны цамхагийн агаар сэлгэлтийн GK-1 системийн ремень, агаар сорох ACC-5 системийн дулааны элементийг шинээр сольж, ACC-2-6 системүүдийн

гадна хайрцагт битүүмж хийсэн. “Буянт-Ухаа” зоогийн газрын хөргөх камерын конденсаторын сэнсний моторт их засвар хийсэн.

Салхивчийн системүүдийн цахилгаан хөдөлгүүр, хүчний болон удирдлагын хэлхээ, агаарын шугам хоолой, дагалдах тоноглолууд, алсын удирдлагын щит ШД-1, 2-ын тоноглолд үзлэг, үйлчилгээг хийж өвлийн горимд шилжүүлсэн. Мөн гадна агаарын хонгил болон РТМ-1, 2 системийн агаарын шүүлтүүрт цэвэрлэгээ хийж хангалтын агаарын чанарыг сайжруулсан.

Теле мэдээлэл холбооны алба нь нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашигладаг аюулгүй байдлын үзлэгийн рентген төхөөрөмжүүдийн цацрагийн алдагдлыг хэмждэг дозиметр /цацрагийн хэмжилтийн төхөөрөмж/-ийг Цөмийн энергийн комиссын ажлын албаны лабораториор баталгаажилт хийлгэж, аюулгүй байдлын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. Орон нутгийн явагчдын танхимд байрлалтай рентген туяаны төхөөрөмжүүдийн компьютерын процессорт техникийн үйлчилгээ хийж, Транзит танхимд нислэгийн мэдээллийн 4 дэлгэц болон утасгүй интернетийн 4 төхөөрөмж, сүлжээний 2 төхөөрөмж, нисэх буудлын 1, 2 дугаар давхрын мэдээллийн 3 дэлгэцийг шинэчлэн суурилуулсан.

Байгууллагын дотоод сүлжээг сайжруулах зорилгоор технологийн болон дотоод сүлжээний нийт 8 төхөөрөмжийг шинэчлэн сүлжээний төхөөрөмжүүдийн 90%-ийг менежмент, мониторинг хийх боломжтой болсон. Сүлжээний бодит хугацаанд мониторинг хийх цаашдаа ээлжийн инженерүүд тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгаж байх Ipswitch WhatsUP Gold програмыг нэвтрүүлж сервер тоног төхөөрөмжүүдийг холбосон. 14 харуулын цэгт кабелийн монтаж татаж, нисэх буудлын виртуал сүлжээнд холбосон.

Нисэх буудлын хэмжээнд ашиглагддаг дотоод мессенжер Openfire серверт шинэчлэлт хийж spark дотоод сүлжээний програмын шинэ хувилбарыг суулган, загварыг байгууллагын нэр, логотой болгон өөрчилж шинэчилсэн. Авто зогсоолын хураамж авагчийн программд нэмэлт өөрчлөлтүүд оруулж, нисэх буудлын программ хангамж, систем серверүүдийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж, ашиглалтын явцад гарсан гэмтэл дуудлагуудыг тухай бүрт нь засварлаж байна.

Нислэгийн зорчигчийн мэдээллийн системийг шинэчилж байгаатай холбогдуулан SITA системийг хэрэглэгч байгууллагуудыг шинэ системд холбох туршилт, тохируулгын ажлыг SITA болон HANSCOM компанийн инженерүүдтэй хамтран гүйцэтгэж, хэвийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Галын дохиолол байрлуулах шаардлагатай цэгийн судалгааг хийж 200 ширхэг панелийг 100 ширхэг детектор, 8 гар мэдээлэгч, 1 дуут дохио өгөгчийн хамт суурилуулсан.

Иргэний нисэхийн газрын хэмжээнд хийсэн ажлын хүрээнд Ази, Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хурал” /DGCA54/-ын цахим сайт буюу цахим хуудсыг хийж, хөгжүүлэн, өнгө дизайныг тогтмол сайжруулан аюулгүй байдлыг нь хангаж, баталгаажсан мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн ажилласан.

*Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт:* Хүний нөөцийг чадваржуулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилтнуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, ажилтан өөрөө тасралтгүй хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгууллаа.

“Чингис хаан” ОУНБ-ын “Сургалтын нэгдсэн хөтөлбөр”-т олон улсын нисэх буудлуудын зөвлөлийн сургалтын ангиллын дагуу нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилсэн.

2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 25 сургалтад давхардсан тоогоор 846 ажилтныг хамруулсан. Мөн төлөвлөгөөт бус, цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдсан 33 сургалтад 484 ажилтныг хамруулсан.

Тайлангийн хугацаанд 5 ажилтанд мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд нь зориулж их дээд сургуульд суралцах нэг жилийн сургалтын төлбөрийн 70%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгон суралцах нөхцөл бололцоогоор нь хангасан.

ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвд зохион байгуулагдсан англи хэлний 4 удаагийн сургалтад 62 ажилтан, “Гүрэн” дээд сургуулиас зохион байгуулсан “Нисэхийн англи хэлний сургалт”-д 68 ажилтан, нийт 130 ажилтныг англи хэлний шаталсан сургалтад хамруулсны дээр



үйлчилгээний ажилтнуудын ажлын байранд ашиглах англи хэлний гарын авлагыг шинээр хийж, АБХА, ЗҮА, АШҮА-ны ажилтнуудын өдөр тутмын хэрэглээ болгоод байна.

Мөн ажилтнуудын англи хэл сурах хүсэл эрмэлзлэлийг идэвхжүүлэх, авьяасыг нээн илрүүлж, хөгжүүлэх зорилгоор 2017 оны 05 дугаар сард “Let’s speak English” англи хэлний тэмцээнийг алба, нэгжүүдийн дунд зохион байгуулсан.

2017 онд нийт 13 гадаад сургалтад 43 ажилтныг хамруулах ажлыг зохион байгуулсан.

Үүнд:

- ✓ Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан 4 сургалтад 13 ажилтан,
- ✓ Олон Улсын Нисэх Буудлуудын Зөвлөлөөс зохион байгуулсан 3 сургалтад 5 ажилтан,
- ✓ 2017 оны 04 дүгээр сарын 22-28-ний өдрүүдэд австри улсад зохион байгуулагдсан галын автомашины анхан шатны сургалтад Аврах, гал унтраах албаны 10 ажилтан хамрагдан, батламж авсан.
- ✓ БНСУ-ын “Инчеон” ОУНБ-ын Нисэхийн академи дээр зохион байгуулагдсан “Нисэх буудлын үйл ажиллагаа ба менежмент” сэдэвт сургалтад 6 ажилтан хамрагдаж гэрчилгээжсэн.
- ✓ Бусад гадаадын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан 4 сургалтад 9 ажилтан хамрагдсан байна.

Захиргаа, хүний нөөцийн хэлтэс нь 2017 онд 348 ажилтантай хөдөлмөрийн хугацаатай болон хугацаагүй гэрээ байгуулж, өөрийн хүсэлтээр 10, иргэний нисэхийн систем хооронд шилжин ажилласан 36, өндөр насны тэтгэвэрт гарсан 9, сахилгын ноцтой зөрчил гаргасан 14, групп тогтоолгосон 2, нас барсан 1, нийт 73 ажилтныг ажлаас чөлөөлсөн.

Хүний нөөцийн шинэ программд 752 ажилтны мэдээллийг шинээр болон баяжуулан бүртгэж, хувийн хэргийн хөтлөлт, баяжилт, нийгмийн даатгалын дэвтэрт шилжилт хөдөлгөөний бичилтийг тогтмол хийж байна.

Хүний нөөцтэй холбоотой 18 төрлийн бүртгэл хөтлөн, нэмэлт өөрчлөлтийг тухай бүрт нь хийж байна. Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэрт гарсан 11 ажилтныг ИНЕГ-ын ахмадын хороонд бүртгүүлж, удирдах дээд байгууллага болон бусад байгууллагад нийт 16 төрлийн бүртгэл, судалгааг тогтоосон хугацаанд нь хүргүүлснээс ИНЕГ-т 14, ХУД-ийн цэргийн штабд 1, Төрийн тусгай хамгаалалтын газарт 1 байна.

Захиргааны зүгээс байгууллагын дотоод журмын хэрэгжилт, ажлын цаг ашиглалт, ажлын байрны эмх цэгц, дэг журамд үзлэг шалгалтыг 11 удаа хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 47 ажилтны 50 зөрчилд сахилгын шийтгэл ногдуулснаас 20 ажилтанд сануулах, 11 ажилтанд үндсэн цалинг 20 хувиар бууруулах, 19 ажилтныг ажлаас халах арга хэмжээ авсан. Сахилгын зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.6%-иар буурсан байна.

2017 онд ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг хөдөлмөрийн дотоод журам болон Хамтын гэрээнд заасны дагуу шийдвэрлэж нийт 113 ажилтанд тэтгэмж, тусламжийг олгосны дээр 313 эмэгтэй ажилтанд 50,000 төгрөгийн гарын бэлэг, 461 ажилтны 835 хүүхдэд 20,000 төгрөгийн гарын бэлэг, гэрт буюу ердийн галлагаатай сууцанд амьдардаг 200 ажилтанд 200,000 төгрөгийн түлээ нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлсэн.

2017 онд “Чингис хаан” ОУНБ нь “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнуулсны дээр 12 ажилтан төрийн одон медаль, 67 ажилтан ЗТХЯ-ны шагнал, 26 ажилтан ИНЕГ-ын шагнал, 87 ажилтан байгууллагын шагнал, 30 ажилтан бусад шагналаар нийт 222 ажилтан тус тус шагнагдсан байна. Энэ нь нийт ажилтнуудын 29,5%-ийг эзэлж байна.

*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:* Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, эрх зүйн актуудыг ажилтнуудад сурталчлан таниулах зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн актуудын шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалтыг зохион байгуулж, Аврах, гал унтраах алба, Аэродромын албаны нийт 90 ажилтныг хамруулсан.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар гарын авлага, таниулах материалыг цахим хуудсанд шинээр байршуулан алба, нэгжүүдийн мэдээллийн самбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуй, гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлийн танилцуулга, мэдээ мэдээллүүдийг шинэчилсэн.

*Галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх:* 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 01 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл “Чингис хаан” олон улсын нисэх буудал, түүний харьяа албад болон түрээсээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөрчлийг арилгуулсан.

Нисэх буудлын барилга байгууламжийн осол аваарын үед дүрвэн гарах 70 схем зургийг шинэчлэн байршуулсан.

ИНЕГ-ын даргын 2017 оны А/61 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, 2017 оны 02 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд тус нисэх буудлын хамгаалагдсан бүсэд байрлах аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байранд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийсэн. Үзлэг шалгалтыг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран явуулж тайланг 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ИНЕГ-ын удирдлагад танилцуулсан.

ИНЕГ-ын даргын 2017 оны 02 тоот албан даалгавар, ИНЕГ-ын НББЗХ-ээс ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу болон нисэх буудлын барилга, байгууламжуудад галын үзлэгийг 8 удаа хийж, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.

Гал унтраагуурын бэлэн байдлыг шалгаж, ажиллагаагүй болсон 19 гал унтраагуурыг мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлж, ажилтнуудыг дадлагажуулах галтай сургалтад ашигласан. Гэмтэлтэй 10 шлангийг сольж, шлангийн эвхэлтийг шилжүүлж цооролтоос сэргийлсэн.

Нийтийн хоол үйлчилгээний албаны халуун цех, шинээр ашиглалтад оруулсан гаалийн баталгаат агуулах, агаарын хөлөг залгах хоолойнуудын галын аюулгүй байдлыг хангахад зориулж 58 гал унтраагуурыг худалдан авч хангалт хийн бэлэн байдлыг хангасан.

2017 онд “Чингис хаан” ОУНБ-д “Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар хийх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Энэ ажлын хүрээнд дадлага сургууль хийх бэлтгэлийг хангаж серена дохиог урьдчилан дуугаргаж туршсанаас гадна ослын гарцуудын бэлэн байдлыг шалгаж, дүрвэх бүдүүвч, чиг заасан гэрлэн тэмдэглэгээ, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдалд үзлэг хийсэн.

*Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр:* “Чингис хаан” ОУНБ-ын хамт олон 2017 онд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх уриатайгаар ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, “Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай үйл ажиллагааг зохицуулах журам” нэртэйгээр баталгаажуулан журмын хэрэгжилтийг хангах зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Тус нисэх буудлын [www.airport.gov.mn](http://www.airport.gov.mn) цахим хуудсаар дамжуулан нисэх буудлын үйл ажиллагаа, үйлчилгээ болон үйлчилгээний үнэ тариф, нислэгийн цагийн хуваарь, нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын талаарх мэдээ, мэдээллийг ард иргэдэд хүргэхийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуульд заасан “ил тод байх, ард түмэнд үйлчлэх” гэсэн зарчмын хүрээнд Иргэний нисэхийн салбарын болон нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг үйлчлүүлэгчдэд хүргэж байна.

2017 онд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, ажилтнуудын харилцааны соёл, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Инээмсэглэл, Эелдэг харилцаа” аяныг зохион байгуулж, аяны хүрээнд дараах ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

- 07 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд “Монголын зочлох үйлчилгээний удирдлагын академи”-тай хамтран “Инээмсэглэх ур чадвар, харилцааны соёл”-ын сургалтыг зохион байгуулж АБХА, АШҮА, ЗҮА, НХҮА-ны нийт 192 ажилтныг 8 ээлжээр хамруулан гэрчилгээжүүлсэн
- 09 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд “Хүндэт болон дипломат зочдод үйлчлэх соёл” практик сургалтыг зохион байгуулж, нийтийн хоол, үйлчилгээний алба, ЗҮА-ны үйлчилгээний 17 ажилтныг хамруулсан.
- Ажилтнуудыг үйлчлүүлэгч, зорчигчидтой инээмсэглэн, харилцааны өндөр соёлтой үйлчлэхийг уриалсан зурагт хуудас, сурталчилгааны материалуудыг хийж, мэдээллийн самбар, ажилчдын амрах, хувцас солих өрөө зэрэг ил тод харагдахуйц газруудад байрлуулсан.
- Эмэгтэй ажилтнуудын хувцаслалт, гоёл чимэглэлийн зүйлсийн хэрэглээ, үс засалт, нүүр будалтад онцгойлон анхаарч, ОУ-ын стандартаар зурагт хуудас бэлтгэн нэгжийн

эмэгтэй ажилтнуудад танилцуулан, стандартын дагуу хувцаслаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилласан.

Энэхүү аяныг зохион байгуулснаар үйлчилгээний ажилтнуудын хувцаслалт, дүрэмт хувцасны жигдрэлт эрс сайжирсан бөгөөд зорчигч, үйлчлүүлэгчидтэй харилцах харилцааны соёл сайжирсан юм. Мөн хүндэт зочны танхимын үйлчлэх ажилтнуудыг хүндэт зочдод үйлчлэх практик сургалтад хамруулснаар тэдний үйлчилгээний ур чадвар, мэдлэг сайжирсан.

2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр нисэх буудал дээр зохион байгуулсан “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх үйл ажиллагаа” сургалтад 88 ажилтныг хамруулсан.

*Шинэ нисэх буудал руу нүүх бэлтгэлийг хангах чиглэлээр:* ИНЕГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/202 дугаар тушаалаар байгуулагдсан “Чингис хаан” ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг шинэ нисэх буудал руу нүүлгэн шилжүүлэх ажлын хэсэгт тус нисэх буудлын захирал болон ҮТЗХХ-ийн дарга нар орж ажилласан. Энэ ажлын хүрээнд нэгдсэн төлөвлөгөөнд тусгах ажлын жагсаалт, холбогдох тооцоо судалгааг гаргахаар нисэх буудал дээр ажлын хэсэг томилогдон ажилласан.

2017 оны 06 дугаар сарын 29-нд Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд онцгой байдлын ширээний дасгал сургуулилтыг зохион байгуулсан. Түүнчлэн нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөг ширээний дасгал сургуулилтаар шалгах, сайжруулах болон /ORAT/ тест хийх ажиллагааг шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх Захиргаатай хамтран гүйцэтгэлээ.

Шинэ нисэх буудлын төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй аэродромын цас цэвэрлэгээний машин механизмуудыг “Аэромонголиа” ХХК-ийн ангарт байрлуулахтай холбогдох сургалтыг зохион байгуулсан. Тус ангарт байрлуулсан автомашин, тоног төхөөрөмжүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг холбогдох байгууллага, алба, нэгжүүдтэй хамтран зохион байгуулж байна.

*Төлөвлөлт, санхүүгийн үйл ажиллагаа:* 2018 оны байгууллагын орон тоо, цалингийн сангийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулж, ИНЕГ-т хүргүүлсэн.

2017 онд Ажил гүйцэтгэх 30 гэрээ, Худалдах, худалдан авах гэрээ 60, Хамтран ажиллах гэрээ 17, Агаарын тээвэрлэгч 4 байгууллагатай нисэх буудлын ашиглалтын гэрээг тус тус байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.

Тус нисэх буудлын албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар 74 аж ахуйн нэгжтэй, сурталчилгааны самбарын зориулалтаар 24 байгууллагатай гэрээ байгуулж ажилласнаар нийт 2888,7 м.кв талбай түрээс 965,884,832 сая төгрөгийн орлого, сурталчилгааны самбарын түрээсээс 212,112,534 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

*Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо:* 2017 онд “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны заавар”-ыг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлж байна. Зааврын хэрэгжилт 92%-тай байна.

Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны бүтцийг шинэчлэн баталж, аюулгүй ажиллагааны хороо болон аюулгүй ажиллагааны хэсгүүдийг байгуулсан. 2017 онд аюулгүй ажиллагааны хороо 2 удаа, аюулгүй ажиллагааны хэсгүүд нийт 12 удаа хуралдаж, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэсэн.

Нисэх буудлын аюулгүйн бүсэд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хамтын ажиллагаа болон болзошгүй эрсдэлийг хамтран шийдвэрлэх зорилготой иргэний нисэхийн салбарын нэгжүүдийн төлөөллөөс бүрдсэн “Аэродромын аюулгүй ажиллагааны баг”-ийг шинэчлэн байгуулж, ИНЕГ-ын даргын 2017 оны А/316 тушаалаар батлуулсан. Аэродромын аюулгүй ажиллагааны баг 1 удаа хуралдаж, холбогдох шийдвэрийг гарган хэрэгжүүлж ажилласан байна.

2017 онд гадны биет, хаягдлын судалгааг сүүлийн 5 жилээр, байгууллагын хэмжээн дэх эрсдэлийн судалгааг 2017 оны байдлаар тус тус гаргаж, нисэх буудлын аэродромын хяналтын код 4D ангиллаас хэтэрсэн 4E, 4F ангиллын захиалгат болон тогтмол агаарын хөлгүүд нислэг үйлдэж байгаад эрсдэлийн үнэлгээ хийсэн.

2017 онд аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 93 ажилтныг хамруулсан. Үүнд:

- ✓ “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо” мэдээллийн сургалтыг 5 удаа,
- ✓ “Эрсдэлийн удирдлага” сэдэвт мэдээллийн сургалтыг 3 удаа,

✓ ГЕГ-тай хамтарсан “Эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг 1 удаа

*Дотоод хяналтын үйл ажиллагаа:* ИНЕГ-ын НААХЗА-наас 2017 онд Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх ИНД140-ийн шаардлагын дагуу аюулгүй байдлын чиглэлээр төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус үзлэг шалгалтыг 7 удаа, Аэродромын гэрчилгээжилт, үйл ажиллагаа ИНД139-ийн дагуу аюулгүй ажиллагааны чиглэлээр төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 2 удаа тус тус хийсэн байна.

Мөн ИНЕГ-ын навигацийн үзлэгт жилд 2 удаа шалгагдаж, шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тус нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагаанд ЗТХЯ, Сангийн яамны хамтарсан шалгалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шалгалт, Татварын ерөнхий газрын шалгалт, ИНЕГ-ын дотоод аудитын албаны шалгалт 2, нийт 5 удаа шалгалт хийсэн байна. ЗТХЯ, Сангийн яамны хамтарсан шалгалтаар өгөгдсөн 31 зөвлөмжийн биелэлт 86%, ТӨБЗГ-ын шалгалтаар 2 дутагдал, цаашид анхаарах арга хэмжээний 7 саналыг ирүүлсэн ба залруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 85%-тай байна.

“Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт хийх зорилгоор “Дотоод аудит явуулах орон тооны бус баг”-ийг Захирлын 2017 оны А/34 тоот тушаалаар байгуулсан. Аудитын багийн гишүүд 2017 оны 04 дүгээр сарын 10-наас 24-ний өдрүүдэд “Аудит шалгалт хийх удирдамж”-ийн дагуу нисэх буудлын 17 нэгжид аудит шалгалт хийж, шалгалтын тайлан, дүгнэлт, 174 зөвлөмжийг нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийн давтан шалгалтыг 10 дугаар сард хийсэн ба 174 зөвлөмжийн биелэлт 76%-тай байна.

2017 оны 04 дүгээр сарын 26-наас 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж буй 24 гэрээт байгууллагуудад аудит хийсэн. Мөн Ашиглалтын гэрээ, “Аэродромын заавар”, Перрон зохицуулалтын журмуудын хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор тус нисэх буудалтай хамтран ажилладаг нийт 13 агаарын тээвэрлэгч болон ИНЕГ-ын холбогдох алба, нэгжүүдэд шалгалтын асуулгыг хүргүүлж, асуулгын хариулт, холбогдох нотолгоог ирүүлсэн байгууллагуудын хариултыг шалган, тайлан, дүгнэлтийг гаргаж, зөвлөмжийг хүргүүлсэн.

“ЧИНГИС ХААН” ОУНБ-ЫН  
ЗАХИРАЛ

Д. МӨНХБААТАР

## ДҮГНЭЛТ

- 2017 онд 1 241 506 зорчигч үйлчлүүлж өмнөх оноос 21,9%-иар, 13326 нислэг үйлдэгдэж 16.9%-иар тус тус өссөн ба нисэх буудлын хамт олон нислэг үйлдвэрлэл, үйлчилгээг аюулгүй, тасралтгүй, шуурхай зохион байгуулж ажилласан.
- 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 29.9 тэрбум төгрөгийн орлого, 24.6 тэрбум төгрөгийн зардал, 5.3 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 14.9%-ийн орлогын өсөлттэй байна.
- Нисэх буудлын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн аюул эрсдэлийг тооцон илрүүлэх, залруулгын арга хэмжээг тодорхойлж, шийдвэрлэх эхлэлийг тавиад байна.
- Олон улсын Чанарын менежментийн тогтолцооны стандартын шинэчлэлтэй холбогдуулан ISO 9001:2015 /MNS ISO 9001:2016/-д шилжих бэлтгэл ажлыг хангаж, Стандартчлал хэмжилзүйн газрын аудитад 2017 оны 5 дугаар сард шалгуулан, нисэх буудлын үйлчилгээ нь шинэ стандарт хангаж буйг гэрчлэх ISO 9001:2015 гэрчилгээг 2020 он хүртэл буюу 3 жилийн хугацаатай эзэмших эрх авсан.
- “Чингис хаан” ОУНБ-ын хамт олон нь удирдах дээд байгууллагаас ирүүлсэн Албан даалгавар, тушаал, шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.
- 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 92.6%-тай ханган биелүүлсэн.

## ЦААШДЫН ЗОРИЛТ:

2018 оны тэргүүлэх зорилт:

“Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх”

Зорилт нэг: “Байгууллагын санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх”

Зорилт хоёр: “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх”

Зорилт гурав: “Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалтыг сайжруулах”

Зорилт дөрөв: “Хүний нөөцийг чадваржуулах”